

2008.02.28

Дугаар 24

“МИГ даатгал” ХХК-д ердийн даатгалын зарим
хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3,
Даатгалын тухай хуулийн 20.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн
зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

Нэг.“МИГ даатгал” ХХК-д даатгалын дараах хэлбэрүүдээр ердийн даатгалын
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай. Үүнд:

1. Орон сууцны хариуцлагын /1.3.5/;
2. Гэрээний хариуцлагын /1.3.12/;
3. Бизнес тасалдлын /1.4.1/.

Хоёр.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж
ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, “МИГ даатгал” ХХК-ийн ердийн
даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ
тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрүүдийг нэмж бүртгэхийг Тамгын
газар /Ж. Жадамбаа/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ